

ТАРИАЛСАН ТАЛБАЙН 20... ОНЫ....-Р САРЫН МЭДЭЭ (ХАА-6)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн өрх болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас тогтоосон хугацаанд нөхөж авна.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

1. Байршил: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

2. Өрхийн мэдээлэл:

- Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар. Тухайн өрхөд харьяалах баг, хорооноос олгосон 12 оронтой “Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар”-ыг бичнэ.
- Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэрийг бичнэ.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл:

- Регистрийн дугаар. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ.
- Аж ахуйн нэгж, байгууллагын нэр. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг товчлолгүйгээр бичнэ.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

1. Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал, бусад

Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал болон бусад ургамлын тариалсан талбайг бүгд дүн, усалгаатай талбай гэсэн ангиллаар 1-22 дугаар мөрөнд өгөгдсөн ургамлын нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ. Нийт тариалсан талбайн дүнгээс усалгаатай талбайн дүнг сугалж нөхнө.

1 дүгээр баганд тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн нийт талбай дүнг асууж нөхнө. 1 дүгээр баганын дүн нь 2 дугаар баганын дүнгээс их буюу тэнцүү байна.

2 дугаар баганд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

1-8 дугаар мөрөнд үр тарианы тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Үр тарианы тариалсан талбайг буудай, арвай, овьёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан, бүртгэнэ. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы тариалсан талбайд оруулахгүй. 1 дүгээр мөрийн дүн нь 2-8 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

9 дүгээр мөрөнд төмсний тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

10-15 дугаар мөрөнд тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлыг тэжээлийн ургамлын тариалсан талбайд хамруулна. Тэжээлийн ургамлын тариалсан талбайг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайгаас эрдэнэшишийн тариалсан талбайг ялгаж, нөхнө. 10 дугаар мөрийн дүн нь 11-13, 15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

11 дүгээр мөрөнд ногоон тэжээлийн тариалсан талбайн хэмжээг асууж, нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овъёос, гурвалжин будаа зэргийн тариалсан талбайг ногоон тэжээлийн тариалсан талбайд хамруулна.

12 дугаар мөрөнд олон наст ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Тухайлбал, жимс, жимсгэний мод, бут гэх мэт.

13 дугаар мөрөнд даршны ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайд малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын тариалсан талбайн хэмжээг хамруулна. 13 дугаар мөрийн дүн нь 14 дүгээр мөрийн дүнгээс их буюу тэнцүү байна.

14 дүгээр мөрөнд эрдэнэшишийн тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. 14 дүгээр мөрийн дүн нь 13 дугаар мөрийн дүнгээс бага буюу тэнцүү байна.

15 дугаар мөрөнд дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

16-20 дугаар мөрөнд техникийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зорилгоор тариалсан техникийн ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Техникийн ургамлын тариалсан талбайг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. Рапс, наранцэцгийн тариалсан талбайн хэмжээ нь тосны ургамлын тариалсан талбайн хэмжээ болно. 16 дугаар мөрийн дүн нь 17-20 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

21 дүгээр мөрөнд эмийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө.

22 дугаар мөрөнд маягтанд тусгагдаагүй бусад нэр төрлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө.

2.Хүнсний ногоо

Хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг бүгд дүн, усалгаатай талбай, хүлэмжийн талбай гэсэн ангиллаар 23-36 дугаар мөрөнд өгөгдсөн хүнсний ногооны нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр багананд тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн нийт талбай дүнг асууж нөхнө. 1 дүгээр баганын дүн нь 2 дугаар баганын дүнгээс их буюу тэнцүү байна.

2 дугаар багананд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн

дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

3 дугаар багананд хүлэмжинд тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Хүлэмж гэдэг нь хөрсийг хамгаалж, таримал ургамал ургуулах зорилгоор барьсан байгууламжийг хэлнэ. Хүлэмжийн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж тавина. 3 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

23-36 дугаар мөрөнд хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хүнсний ногооны тариалсан талбайг байцаа, лууван, шар манжин, улаан манжин, сонгино, сармис, өргөст хэмх, улаан лооль, тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. 23 дугаар мөрийн дүн нь 24-36 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

Тариалсан талбайн хэмжээг га-гаар илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд доор өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлнэ.

Талбайг га-д шилжүүлэх итгэлцүүр:

$$1 \text{ га} = 10000 \text{ м}^2 = 100 \text{ м} * 100 \text{ м}, 1 \text{ сот} = 100 \text{ м}^2 = 10 \text{ м} * 10 \text{ м}, 100 \text{ сот} = 10000 \text{ м}^2 = 1 \text{ га}$$

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАРИАЛСАН ТАЛБАЙН 20... ОНЫ МЭДЭЭ (ХАА-7а)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас тогтоосон хугацаанд нөхөж авна.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг.

- Регистрийн дугаар. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ.
- Аж ахуйн нэгж, байгууллагын нэр. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг бичнэ.
- Байршил. Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо, тухайн байгууллагын утасны дугаар зэрэг үзүүлэлтүүдийг нөхнө.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

1. Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал, бусад

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тариалсан үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал болон бусад ургамлын талбайн хэмжээг бүгд дүн, усалгаатай талбай, бордоо хэрэглэсэн, хортон шавьж устгах бодис хэрэглэсэн, хортон шавьж устгах бодис хэрэглэсэн гэсэн ангиллаар 1-22 дугаар мөрөнд өгөгдсөн ургамлын нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр багананд эргэлтийн талбайн хэмжээг асууж нөхнө. Эргэлтийн талбайд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар тариалангийн зориулалттай нийт талбайн хэмжээг хамруулна. 1 дүгээр баганын дүн нь 2 болон 6 дугаар баганын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2 дугаар багананд тариалсан талбайн хэмжээг нөхнө. Тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн талбайн хэмжээг тариалсан талбайд хамруулан бүртгэнэ. Тариалсан талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

3 дугаар багананд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 3 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

4 дүгээр багананд бордоо хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Ургамлыг хамгаалах, хөрс сайжруулах зорилгоор ашигласан эрдэс, органик бодис буюу бордоогоор бордсон талбайн хэмжээг бордоо хэрэглэсэн талбайд хамруулна. Бордоо хэрэглэсэн

талбайн дүнг нийт тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 4 дүгээр баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

5 дугаар багананд хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хортон шавьж устгах зорилгоор тусгай бодис ашигласан талбайн хэмжээг үүнд хамруулан бүртгэнэ. Хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 5 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

6 дугаар багананд өнжсөн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Өнжсөн талбайд хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, сайжруулах зэрэг шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгдээгүй талбайн хэмжээг хамруулна. Өнжсөн талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 6 дугаар баганын дүн 1 дүгээр баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

1-8 дугаар мөрөнд үр тарианы тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Үр тарианы тариалсан талбайг буудай, арвай, овьёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы тариалсан талбайд оруулахгүй. 1 дүгээр мөрийн дүн нь 2-8 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

9 дүгээр мөрөнд төмс тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

10-15 дугаар мөрөнд тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлыг тэжээлийн ургамлын тариалсан талбайд хамруулна. Тэжээлийн ургамлын тариалсан талбайг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайгаас эрдэнэшишийн тариалсан талбайг ялгаж, нөхнө. 10 дугаар мөрийн дүн нь 11-13,15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

11 дүгээр мөрөнд ногоон тэжээлийн тариалсан талбайн хэмжээг асууж, нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийн тариалсан талбайг ногоон тэжээлийн тариалсан талбайд хамруулна.

12 дугаар мөрөнд олон наст ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Тодорхой нэг жилд тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Тухайлбал, жимс, жимсгэний мод, бут гэх мэт

13 дугаар мөрөнд даршны ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайд малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын тариалсан талбайн хэмжээг хамруулна.

14 дүгээр мөрөнд эрдэнэшишийн тариалсан талбайн хэмжээг нөхнө. 14 дүгээр мөрийн дүн нь 13 дугаар мөрийн дүнгээс бага буюу тэнцүү байна.

15 дугаар мөрөнд дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

16-20 дугаар мөрөнд техникийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зориулалтаар тариалсан техникийн ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Техникийн ургамлын тариалсан талбайг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. Рапс, наранцэцгийн тариалсан талбайн хэмжээ нь тосны ургамлын тариалсан талбайн

хэмжээ болно. 16 дугаар мөрийн дүн нь 17-20 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

21 дүгээр мөрөнд эмийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө.

22 дугаар мөрөнд бусад буюу маяганд тусгагдаагүй нэр төрлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө.

2. Уринш

23 дугаар мөрөнд уринш хийсэн талбайн хэмжээг асууж нөхнө. Уринш хийсэн талбайд дараа жил ургамал тариалах зорилгоор боловсруулж өнжөөсөн тариалангийн талбайн хэмжээг хамруулна. Уриншийн хувьд 1 дүгээр баганын дүн нь 2 дугаар баганын дүнгээс их буюу тэнцүү байна.

3. Хүнсний ногоо

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тариалсан хүнсний ногооны талбайг бүгд дүн, усалгаатай талбай гэсэн ангиллаар 24-37 дугаар мөрөнд өгөгдсөн нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр багананд эргэлтийн талбайн хэмжээг асууж нөхнө. Эргэлтийн талбайд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар тариалангийн зориулалттай нийт талбайн хэмжээг хамруулна. 1 дүгээр баганын дүн нь 2 болон 6 дугаар баганын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2 дугаар багананд тариалсан талбайн хэмжээг нөхнө. Тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн талбайн хэмжээг тариалсан талбайд хамруулан бүртгэнэ. Тариалсан талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

3 дугаар багананд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистернт, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 3 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

4 дүгээр багананд бордоо хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Ургамлыг хамгаалах, хөрс сайжруулах зорилгоор ашигласан эрдэс, органик бодис буюу бордоогоор бордсон талбайн хэмжээг бордоо хэрэглэсэн талбайд хамруулна. Бордоо хэрэглэсэн талбайн дүнг нийт тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 4 дүгээр баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

5 дугаар багананд хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хортон шавьж устгах зорилгоор тусгай бодис ашигласан талбайн хэмжээг үүнд хамруулан бүртгэнэ. Хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 5 дугаар баганын дүн нь 1 буюу 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

6 дугаар багананд хүлэмжинд тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Хүлэмж гэдэг нь хөрсийг хамгаалж, таримал ургамал ургуулах зорилгоор барьсан байгууламжийг хэлнэ. Хүлэмжийн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 6 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

7 дугаар багананд өнжсөн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Өнжсөн талбайд хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, сайжруулах зэрэг шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгдээгүй талбайн хэмжээг хамруулна. Өнжсөн талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 7 дугаар баганын дүн 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

24-37 дугаар мөрөнд хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хүнсний ногооны тариалсан талбайг байцаа, лууван, шар манжин, улаан манжин, сонгино, сармис, өргөст хэмх, улаан лооль, тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. 24 дүгээр мөрийн дүн нь 25-37 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

Тариалсан талбайн хэмжээг га-гаар илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд доор өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлнэ.

ӨРХИЙН ТАРИАЛСАН ТАЛБАЙН 20 ... ОНЫ МЭДЭЭ(ХАА-7б)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн өрхөөс тогтоосон хугацаанд нөхөж авна.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

- Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар. Тухайн өрхөд баг, хорооноос олгосон өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаарыг бичнэ.
- Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэрийг бичнэ.
- Байршил. Өрхийн оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо, утасны дугаар зэрэг үзүүлэлтүүдийг нөхнө.

II. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

1. Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал, бусад

Тухайн өрхийн тариалсан үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамал, эмийн ургамал болон бусад ургамлын талбайн хэмжээг бүгд дүн, усалгаатай талбай, бордоо хэрэглэсэн, хортон шавьж устгах бодис хэрэглэсэн, хортон шавьж устгах бодис хэрэглэсэн гэсэн ангиллаар 1-22 дугаар мөрөнд өгөгдсөн ургамлын нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр багананд эргэлтийн талбайн хэмжээг асууж нөхнө. Эргэлтийн талбайд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар тариалангийн зориулалттай нийт талбайн хэмжээг хамруулна. 1 дүгээр баганын дүн нь 2 болон 6 дугаар баганын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2 дугаар багананд тариалсан талбайн хэмжээг нөхнө. Тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн талбайн хэмжээг тариалсан талбайд хамруулан бүртгэнэ. Тариалсан талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

3 дугаар багананд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 3 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

4 дүгээр багананд бордоо хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Ургамлыг хамгаалах, хөрс сайжруулах зорилгоор ашигласан эрдэс, органик бодис буюу бордоогоор бордсон талбайн хэмжээг бордоо хэрэглэсэн талбайд хамруулна. Бордоо хэрэглэсэн талбайн дүнг нийт тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 4 дүгээр баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

5 дугаар багананд хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хортон шавьж устгах зорилгоор тусгай бодис ашигласан талбайн хэмжээг үүнд хамруулан бүртгэнэ. Хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 5 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

6 дугаар багананд өнжсөн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Өнжсөн талбайд хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, сайжруулах зэрэг шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгдээгүй талбайн хэмжээг хамруулна. Өнжсөн талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 6 дугаар баганын дүн 1 дүгээр баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

1-8 дугаар мөрөнд үр тарианы тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Үр тарианы тариалсан талбайг буудай, арвай, овьёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы тариалсан талбайд оруулахгүй. 1 дүгээр мөрийн дүн нь 2-8 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

9 дүгээр мөрөнд төмс тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

10-15 дугаар мөрөнд тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлыг тэжээлийн ургамлын тариалсан талбайд хамруулна. Тэжээлийн ургамлын тариалсан талбайг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайгаас эрдэнэшишийн тариалсан талбайг ялгаж, нөхнө. 10 дугаар мөрийн дүн нь 11-13, 15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

11 дүгээр мөрөнд ногоон тэжээлийн тариалсан талбайн хэмжээг асууж, нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийн тариалсан талбайг ногоон тэжээлийн тариалсан талбайд хамруулна.

12 дугаар мөрөнд олон наст ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Тодорхой нэг жилд тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Тухайлбал, жимс, жимсгэний мод, бут гэх мэт

13 дугаар мөрөнд даршны ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө. Даршны ургамлын тариалсан талбайд малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын тариалсан талбайн хэмжээг хамруулна.

14 дүгээр мөрөнд эрдэнэшишийн тариалсан талбайн хэмжээг нөхнө. 14 дүгээр мөрийн дүн нь 13 дугаар мөрийн дүнгээс бага буюу тэнцүү байна.

15 дугаар мөрөнд дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн тэжээлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө.

16-20 дугаар мөрөнд техникийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зориулалтаар тариалсан техникийн ургамлын тариалсан талбайг үүнд хамруулна. Техникийн ургамлын тариалсан талбайг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. Рапс, наранцэцгийн тариалсан талбайн хэмжээ нь тосны ургамлын тариалсан талбайн хэмжээ болно. 16 дугаар мөрийн дүн нь 17-20 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

21 дүгээр мөрөнд эмийн ургамлын тариалсан талбайг асууж нөхнө.

22 дугаар мөрөнд бусад буюу маягтанд тусгагдаагүй нэр төрлийн ургамлын тариалсан талбайн хэмжээг нөхнө.

2. Уринш

23 дугаар мөрөнд уринш хийсэн талбайн хэмжээг асууж нөхнө. Уринш хийсэн талбайд дараа жил ургамал тариалах зорилгоор боловсруулж өнжөөсөн тариалангийн талбайн хэмжээг хамруулна. Уриншийн хувьд 1 дүгээр баганын дүн нь 2 дугаар баганын дүнгээс их буюу тэнцүү байна.

3. Хүнсний ногоо

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тариалсан хүнсний ногооны талбайг бүгд дүн, усалгаатай талбай гэсэн ангиллаар 24-37 дугаар мөрөнд өгөгдсөн нэр төрөл бүрээр асууж бүртгэнэ.

1 дүгээр багананд эргэлтийн талбайн хэмжээг асууж нөхнө. Эргэлтийн талбайд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар тариалангийн зориулалттай нийт талбайн хэмжээг хамруулна. 1 дүгээр баганын дүн нь 2 болон 6 дугаар баганын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2 дугаар багананд тариалсан талбайн хэмжээг нөхнө. Тухайн жилд үр суулган, тариалалт хийсэн талбайн хэмжээг тариалсан талбайд хамруулан бүртгэнэ. Тариалсан талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

3 дугаар багананд усалгаатай талбайн хэмжээг асууж нөхнө. Тариалалтын явцад ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайн хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистернт, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 3 дугаар баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

4 дүгээр багананд бордоо хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Ургамлыг хамгаалах, хөрс сайжруулах зорилгоор ашигласан эрдэс, органик бодис буюу бордоогоор бордсон талбайн хэмжээг бордоо хэрэглэсэн талбайд хамруулна. Бордоо хэрэглэсэн талбайн дүнг нийт тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 4 дүгээр баганын дүн нь 1 болон 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

5 дугаар багананд хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хортон шавьж устгах зорилгоор тусгай бодис ашигласан талбайн хэмжээг үүнд хамруулан бүртгэнэ. Хортон шавьж устгах бодис хэрэглэсэн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 5 дугаар баганын дүн нь 1 буюу 2 дугаар баганын дүнгээс тус тус бага буюу тэнцүү байна.

6 дугаар багананд хүлэмжинд тариалсан талбайн хэмжээг асууж нөхнө. Хүлэмж гэдэг нь хөрсийг хамгаалж, таримал ургамал ургуулах зорилгоор барьсан байгууламжийг хэлнэ. Хүлэмжийн талбайн дүнг тариалсан талбайн дүнгээс сугалж нөхнө. 6 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

7 дугаар багананд өнжсөн талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Өнжсөн талбайд хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, сайжруулах зэрэг шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгдээгүй талбайн хэмжээг хамруулна. Өнжсөн талбайн дүнг эргэлтийн талбайн дүнгээс сугалж нөхнө. 7 дугаар баганын дүн 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

24-37 дугаар мөрөнд хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээг асууж бүртгэнэ. Хүнсний ногооны тариалсан талбайг байцаа, лууван, шар манжин, улаан манжин, сонгино, сармис, өргөст хэмх, улаан лооль, тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, бусад ургамлын тариалсан талбай гэсэн төрлөөр ангилан бүртгэнэ. 24 дүгээр мөрийн дүн нь 25-37 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

Тариалсан талбайн хэмжээг га-гаар илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд доор өгөгдсөн итгэлцүүрийг ашиглан га-д шилжүүлнэ.

УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН 20 ... ОНЫ ...-Р САРЫН МЭДЭЭ (ХАА-8)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлсэн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага болон өрхөөс тогтоосон хугацаанд нөхөж авна.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

1. Байршил: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, код, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

2. Өрхийн мэдээлэл:

- Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар. Тухайн өрхөд харьяалах баг, хорооноос олгосон

“Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар”-ыг бичнэ.

- Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэрийг товчлолгүйгээр бичнэ.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл:

- Регистрийн дугаар. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ.

- Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг бичнэ.

II. УРГАЦ ХУРААЛТ

1. Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамлын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл

Үр тариа, төмс, тэжээлийн ургамал, техникийн ургамлын ургац, бэлтгэсэн хадлан тэжээлийн хэмжээг нийт хураасан ургац, усалгаатай талбайгаас гэсэн ангиллаар маягтын 1-27 дугаар мөрөнд өгөгдсөн нэр төрлөөр ялган, нөхнө. Нийт хураасан ургацын дүнгээс усалгаатай талбайгаас хураасан ургацын дүнг сугалж нөхнө.

1 дүгээр баганд хураасан нийт ургацын хэмжээг асууж нөхнө. 1 дүгээр баганын дүн нь 2 дугаар баганын дүнгээс их буюу тэнцүү байна.

2 дугаар баганд усалгаатай талбайгаас хураасан ургацыг асууж, нөхнө. Ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайгаас хураасан ургацын хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайгаас хураасан ургацын дүнг нийт хураасан ургацын дүнгээс сугалж нөхнө. 2 дугаар баганын дүн нь 1 дүгээр баганын дүнгээс бага буюу тэнцүү байна.

1-8 дугаар мөрөнд үр тарианы ургацын хэмжээг асууж нөхнө. Үр тарианы ургацыг буудай, арвай, овъёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан

нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овъёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы хураасан ургацад оруулахгүй. 1 дүгээр мөрийн дүн нь 2-8 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

9 дүгээр мөрөнд төмсний ургацын хэмжээг нөхнө.

10-15 дугаар мөрөнд тэжээлийн ургамлын ургацын хэмжээг асууж бүртгэнэ. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлын ургацыг тэжээлийн ургамлын ургацад хамруулна. Тэжээлийн ургамлын хураасан ургацыг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын хураасан ургац гэсэн төрлөөр ялган, бүртгэнэ. Даршны ургамлын ургацаас эрдэнэшишийн ургацыг ялган нөхнө. 10 дугаар мөрийн дүн нь 11-13, 15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

11 дүгээр мөрөнд ногоон тэжээлийн ургацын хэмжээг асууж нөхнө. Ногоон тэжээлийн ургацад малын тэжээлийн зориулалтаар тарьсан овъёос, гурвалжин будаа зэргийн ургацыг хамруулан бүртгэнэ.

12 дугаар мөрөнд олон наст ургамлын ургацыг хэмжээг асууж нөхнө. Тодорхой нэг жилд тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын ургацыг үүнд хамруулан нөхнө.

13 дугаар мөрөнд даршны ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Даршны ургамлын ургацад малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын ургацын хэмжээг хамруулна. 13 дугаар мөрийн дүн нь 14 дүгээр мөрийн дүнгээс их буюу тэнцүү байна.

14 дүгээр мөрөнд эрдэнэшишийн ургацын хэмжээг асууж нөхнө. 14 дүгээр мөрийн дүн нь 13 дугаар мөрийн дүнгээс бага буюу тэнцүү байна.

15 дугаар дугаар мөрөнд дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн тэжээлийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

16-20 дугаар мөрөнд техникийн ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зориулалтаар тариалсан техникийн ургамлын ургацыг үүнд хамруулна. Техникийн ургамлын ургацыг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. 16 дугаар мөрийн дүн нь 17-20 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

20 дугаар мөрөнд маягтанд тусгагдаагүй бусад нэр төрлийн техникийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

21 дүгээр мөрөнд бэлтгэсэн өвсний хэмжээг асууж бүртгэнэ. Бэлтгэсэн өвсөнд малын тэжээлд зориулж байгалиас гар болон механик аргаар хураан авсан ургамлыг хамруулна.

22 дугаар мөрөнд бэлтгэсэн даршний хэмжээг асууж нөхнө. Бэлтгэсэн дарш нь тусгай бэлтгэсэн сав, нүхэнд давстай хольж даршилж бэлтгэсэн малын тэжээл юм.

23 дугаар мөрөнд бэлтгэсэн сүрлийн хэмжээг асууж нөхнө. Үр тарианы болон ургамлын үлдэгдэл иш, навчаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг бэлтгэсэн сүрэлд хамруулан бүртгэнэ.

24 дүгээр мөрөнд бэлтгэсэн гар тэжээлийн хэмжээг асууж нөхнө. Байгалиас түүсэн өвс, ургамлаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг гар тэжээлд хамруулна. Тухайлбал, зоодой, өвсөн мушгиа, таана, хөмүүлийн дарш гэх мэт.

25 дугаар мөрөнд бэлтгэсэн хужир, шүүний хэмжээг асууж бүртгэнэ. Хужир, шүүнд байгалиас хурааж, бэлтгэсэн давс, шүүг хамруулна.

26 дугаар мөрөнд эмийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

27 дугаар мөрөнд маягтанд тусгагдаагүй бусад нэр төрлийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

2.Хүнсний ногоо

